



ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН XV ХУРАЛДААНЫ

ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Дугаар 10

Зуунмод

ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.17, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1, 49.5 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

- 1."Хог хаягдлын менежментийг сайжруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.
- 2.Батлагдсан журмыг аймгийн хэмжээнд мэдээлж, мөрдүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга (Д.Мөнхбаатар)-д даалгасугай.
- 3.Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба (Ч.Жавзанпагма)-д үүрэг болсугай.
- 4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Газрын харилцаа, байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн хороонд үүрэг болгосугай.
- 5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА Ц.ЖАМБАЛСҮРЭН

ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛСАН ИРГЭН,
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫГ УРАМШУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Журмын зорилго нь хаягдалгүй техник, технологи нэвтрүүлсэн, хог хаягдлаа бууруулсан, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгахад шинэлэг менежментийг нэвтрүүлсэн хоёрдогч түүхий эдийг цуглуулсан, дахивар нөөц болгон ашигласан, дахин боловсруулсан, эдийн засгийн эргэлтэд оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгох, дэмжлэг үзүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Хог хаягдлыг бууруулах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхэлдэг болон байгаль орчинд ээлтэй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд урамшуулалд хамрагдах, эрх бүхий байгууллага урамшуулал олгох үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

Хоёр. Урамшуулах үйл ажиллагааны чиглэл, шалгуур үзүүлэлт

2.1. Хог хаягдлын менежментийг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавих шаардлага:

2.1.1. Аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах эргүүлэн ашиглах, устгах үйл ажиллагаанд хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй, зардал хэмнэсэн аргачлал, зохион байгуулалтыг нэвтрүүлсэн байх,

2.1.2. Иргэн (өрх) хог хаягдлыг ангилан ялгах, бууруулах оновчтой аргачлал, санаачилга гаргаж хэрэгжүүлсэн байх;

2.2. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, хадгалах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавих шаардлага:

2.2.1. Хог тээвэрлэх тээврийн хэрэгсэл нь зориулалтын битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, ажилчид нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангасан байх;

2.2.2. Ангилан ялгасан хог хаягдлыг тус бүрээр цуглуулан тээвэрлэсэн, зориулалт цэгт хадгалсан, хэрэглээний шаардлага хангасан зориулалтын сав, баглаа боодлыг хэрэглээндээ нэвтрүүлсэн байх;

2.2.3. Өөрийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний үр дүнд болон дам нөлөөгөөр бий болдог хог хаягдлыг цуглуулах, дахин ашиглах, дараагийн шатны боловсруулалтад нийлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байх;

2.2.4. Хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн технологи зохион бүтээх нэвтрүүлэх зэргээр технологийн шинэчлэл хийсэн байх;

2.2.5. Тээвэрлэгчийн хариуцсан нутаг дэвсгэрт ил задгай, бөөгнөрсөн хог хаягдалгүй байх.

2.3. Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах үйл ажиллагааны чиглэл, түүнд тавигдах шаардлага:

2.3.1. Дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэгч эрх бүхий этгээд түүхий эд болох хог хаягдлыг өөрөө болон хог хаягдал цуглуулах эрх бүхий этгээдээр дамжуулан цуглуулж давивар нөөц болгон ашигласан, дахин боловсруулсан, хог хаягдлаар стандартын шаардлага хангасан бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байх;

2.3.2. Хоёрдогч түүхий эд авах цэг байгуулан тогтмол үйл ажиллагаа явуулж хог хаягдлыг ангилан ялгаж, дахивар нөөц цуглуулж, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байх;

2.3.3. Малын өтөг бууцыг цэврээр нь хурааж био бордоо болгон ашгилсан эсвэл боловсруулах үйлдвэрт нийлүүлсэн байх;

2.3.4. Үйлдвэрлэлийн, үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг 20-с дээш хувиар бууруулах арга хэмжээ авсан, хог хаягдлыг ангилан ялгаж дахин ашгилсан, дахин боловсруулсан байх;

Гурав. Урамшуулалд хамрагдах этгээдэд тавих шалгуур үзүүлэлт

3.1. Урамшуулалд хамрагдах иргэн (өрх), аж ахуйн нэгж, байгууллага нь дараах шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

3.2. Урамшуулалд хамрагдах иргэн (өрх):

3.2.1. Иргэн (өрх) нь байнгын оршин суух хаяг, бүртгэлтэй, орчны цэвэрлэгээг тогтмол хийж, цэвэрлэгээнд тогтмол оролцдог, хог хаягдал, орчны бохирдол буурсан үр дүн гарсан, баг, хорооны иргэд үр дүнг батламжилж тодорхойлолт гарган тухайн шатны Засаг даргаар дэмжүүлсэн байна.

3.2.2. Хог хаягдлыг зохих журмын дагуу төрөлжүүлэн ангилан ялгах сав байршуулж ангилан ялгаж хэвшсэн, хоёрдогч түүхий эд авах цэгт тогтмол нийлүүлсэн байх;

3.2.3. Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлсэн бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байх;

3.3. Урамшуулалд хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага:

3.3.1. Аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгж байгууллага байх ба татварын өр төлбөргүй байх;

3.3.2. Хог хаягдлын анхан шатны болон нэгдсэн мэдээллийн санд бүртгүүлж, холбогдох мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хүргүүлсэн байх;

3.3.3. Төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийлгэсэн байх;

3.3.4. Зохих стандартын дагуу хог хаягдлыг ангилан ялгаж дахивар нөөц болгон ашигласан, дахин боловсруулсан болон энэ чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдтэй гэрээ байгуулан тогтмол нийлүүлэх замаар бохирдлыг бууруулсан байх;

3.3.5. Хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн технологи зохион бүтээх, нэвтрүүлэх зэргээр технологийн шинэчлэл хийсэн байх;

Дөрөв. Урамшууллын хэлбэр, хэмжээ

4.1. Энэхүү журмын "Хоёр", "Гурав"-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан иргэн (өрх) 100,0 мянган төгрөг,

аж ахуйн нэгж байгууллагад 300,0 мянган төгрөгийн урамшуулал олгоно.

4.2.Энэ журмын 3.2-д заасан шалгуур үзүүлэлтүүдийг хангаагүй ч анхан шатны эх үүсвэр дээрээ хог хаягдлыг ангилан ялгаж хавшсан гэр хорооллын айл өрх (иргэн)-д 50,0 мянган төгрөгний урамшуулал олгоно.

4.3.Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга, технологи нэврүүлж Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 290 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу "Ногоон гэрчилгээ", "Эко тэмдэг" авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад тухайн жилд нь нэг удаа 200 мянган төгрөгийн урамшуулал олгоно.

4.4.Сумын Засаг дарга нь энэ журамд заасан иргэн (өрх) аж ахуйн нэгж, байгууллагад урамшуулал олгоход шаардагдах хөрөнгийг Төсвийн тухай хууль, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн сумын хог хаягдлын зардлаас санхүүжүүлнэ.

Тав. Урамшуулал олгох үйл ажиллагааг зохион байгуулах

5.1.Сумын Засаг дарга нь энэ журмын дагуу иргэн /өрх/, аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох талаар санал боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

5.2.Энэ журмын "Хоёр", "Гурав"-т заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангасан тус бүр 3 хүртэлх иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгаруулах бөгөөд журмын 4,2-т заасан урамшуулалд хамрагдах өрх(иргэн)-д энэ заалт хамаарахгүй.

5.3.Сумын Засаг дарга нь энэ журмын дагуу шалгарсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг тухайн оны 12 сарын 20-ны дотор багтаан урамшуулна.

5.4.Урамшуулалд хамрагдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь тухайн жилийн 11 сарын 20-ны дотор багтаан энэхүү журмын "Зургаа"-д заасан баримт бичгийг бүрдүүлэн сумын Засаг даргад хүргүүлнэ.

5.5.Сумын Засаг дарга нь урамшуулалд хамрагдах шаардлагыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад батламж мөнгөн урамшууллыг олгож, энэ тухай ажлын 5 хоногт багтаан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж сурталчилна.

5.6.Сумын Засаг дарга нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад олгосон урамшууллын тайланг холбогдох баримт бичгийн хуулбарын хамт 12 сарын 25-ны дотор Байгаль орчин аялал жуулчлалын газарт хүргүүлнэ.

Зургаа. Бүрдүүлэх материал

6.1.Энэ журмын 5.6 заасны дагуу урамшуулалд хамрагдах тухай хүсэлт /аж ахуйн нэгж, байгууллага албан бичиг, иргэн өргөдөл/ гаргах бөгөөд урамшуулалд хамрагдах шаардлагыг хэрхэн хангасан болон үйл ажиллагааны үр дүнгийн талаарх мэдээллийг дэлгэрэнгүй тусгаж, дор дурьдсан холбогдох баримтыг хавсаргасан байна;

6.2. Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;

6.3..Харьяалах сум татварын албаны тодорхойлолт (аж ахуйн нэгж, байгууллагад хамаарна);

6.4.Төслийн талаарх баг, хорооны Засаг даргын, тодорхойлолт;

6.5.Хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаарх тайлан, мэдээлэл.

_____оОо_____